

Процессын доголдолд анхаарал хандуулах шаардлагатай **2024 оны 3 сар**



Юу болов – Үйлдвэрлэлийн процесс гэнэтхэн доголдож, зогслоо. Тонглолийн алдаатай холбоотой доголдол байж болох ч үйлдвэрлэлийн процесс доголдоход яг юу нөлөөлөв?

Төлөвлөгөөт бус зогсолтын үед ажиллагааг эргэн сэргээхэд гол анхаарлаа хандуулах нь бий.

Үйлдвэрлэлийн процессыг ажиллагаанд оруулах гэж яарснаар сайтар оношлох ажлыг орхигдуулах эрсдэлтэй. Хамгийн хурдан шийдэл нь “өмнө нь засварласан аргаараа дахин засах” байдаг ба энэ нь өөр асуудал үүсэх нөхцөл болно.

Мөн, хэвийн ажиллагаа доголдсон үед хяналтын өрөөнд ердийнхөөс олон хүн байж, түслалцаа үзүүлж байж магадгүй. Засварын хүмүүс зогсолт үүсэхэд ямар үйл явдал нөлөөлөв гэдгийг тогтоохоор асуулт асууж байж мэднэ. Талбайн оператор хүмүүс янз бүрийн тоо мэдээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт гаргаж өгөх хүсэлтэд дарагдаж байж мэднэ.

Асуудлыг шийдвэрлэж, хэвийн ажиллагаанд оруулахдаа аюулгүй ажиллагааны асуудлыг авч үзэх хангалттай цаг гаргах хэрэгтэй. Зогсолт болохоос өмнө, эсвэл зогсолт болох үед үйлдвэрлэлийн процесст өөрчлөлт орсон байж болзошгүй ба оношилгоо хийх, дахин залгах явцдаа дүн шинжилгээ хийж, болзошгүй аюултай нөхцөл байдлуудын илрүүлэн шийдвэрлэх шаардлагатай.

Та мэдэх үү?

- Үйлдвэрлэлийн ихэнх процессууд доголдлыг оношлох, шалтгааныг тогтоох, шийдвэрлэх зааварчилгаатай байдаг.
- Мөн оношилгоо хийх зааварт алдаа доголдлыг хэрхэн аюулгүй оношлох, асуудлыг шийдвэрлэхдээ аюулгүй байдлаа хэрхэн хангахыг заасан байдаг.
- Ослын үеийн зогсолт болон хэвийн зогсолтын үед мөрдөгдөх журмууд өөр өөр байх бөгөөд үйлдвэрлэлийн процесс нь горимд ажиллах магадлалтай. Үйлдвэрлэлийн процесс зогссоны дараа тоног төхөөрөмжийн тавил, хаалтын байрлал өөр өөр байж болзошгүй.
- Үйлдвэрлэлийн процесс ямар ч шалтгаанаар зогссон бай Уйл ажиллагааны бэлэн байдлыг хангах хяналт шалгалт хийх ёстой бөгөөд энэ нь Асаахын өмнөх аюулгүй ажиллагааны хяналт шалгалтаас хамаагүй өргөн цар хүрээтэй байна.
- Осолын зогсолт, хэвийн зогсолтын дараа үйлдвэрлэлийн процессыг дахин эхлүүлэх журмууд өөр өөр байж болзошгүй.

Та юу хийх ёстой вэ?

- Хяналтын систем хэрхэн ажилладаг, үйлдвэрлэлийн процесс аюулгүй ажиллах хязгаарын утгууд, зогсолтын утгуудыг ойлгох.
- Оношилгоо хийх зааврыг хэрхэн ашиглах, хэрэгтэй зүйлээ хурдан олохыг мэддэг байх. Заавруудыг үе үе эргэн харж, доголдлыг оношлох алхмуудыг давтдаг байх.
- Аюул эрсдэлийн үнэлгээний үеэр үйлдвэрлэлийн процесс доголдох боломжит бүх шалтгаан, үр дагаврыг авч үзэх. Зарим гажилт зөвхөн чанарын асуудал бус, аюулгүй ажиллагааны асуудал үүсгэж мэднэ.
- Үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах шалгах хуудсыг бөглөж, асаахын өмнө бүх тоног төхөөрөмж зөв тавил дээрээ байгааг шалгах.

Үйлдвэрлэлийн процесс доголдох үед яарахгүй байж, сайн бодох хэрэгтэй!